

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

<i>1. Байнгын хорооны даргыг сонгох тухай</i>	<i>3-4</i>
--	-------------------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 56 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Энхтүвшин;

Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Э.Бат-Амгалан, Л.Гантөмөр, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, С.Эрдэнэболд, Р.Эрдэнэбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 2

Бүгд: 17

88.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 94.1 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 06 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
09 цаг 56 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Ирцийг та бүхэнд танилцуулъя.

Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Лутаагийн Энхнасан нарын гишүүд хүрэлцэн ирснээр 7 сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх 1 асуудал байгаа.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулга хийнэ. Танилцуулгыг Монгол Ардын намын бүлгийн дарга Бат-Эрдэнэ дарга танилцуулна. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг улируулан нэр дэвшүүлж байна.

Ганзоригийн Тэмүүлэн 1981 онд төрсөн. Эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг. Ганзоригийн Тэмүүлэн нь 2003 онд АНУ-ын American university сургуульд Олон улсын харилцааны мэргэжлээр төгсөж, 2005 онд АНУ-ын American university сургуулийг Олон улсын удирдлагын магистр зэрэг хамгаалсан. 2006 онд Ашигт малтмалын газрын Гэрээлэлтийн хэлтэст мэргэжилтэн, 2007 онд Ашигт малтмал газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтэст ахлах мэргэжилтэн, 2008-2009 онд Ашигт малтмалын газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтсийн дарга, 2009-2014 онд Төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн дэд захирал, 2013-2015 онд Оюутолгой ХХК-д ТУЗ-ийн гишүүн, 2014-2015 онд Монгол Улсын Уул уурхайн яамны дэд сайд, 2015 оноос Нийгмийн Ардчилал монголын залуучуудын холбооны Ерөнхийлөгч, 2015 оноос Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн гишүүн, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2022-2024 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 3 удаа сонгогдож ажилласан ажлын туршлага, төрийн албанд ажилласан мэдлэг, ур чадварыг нь харгалзан үзсэний үндсэн дээр Ганзоригийн Тэмүүлэнг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар улируулан сонгохоор нэр дэвшүүлж байна.

Г.Тэмүүлэн: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Нэр дэвшүүлэх асуудлаар өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Асуулттай гишүүд байна уу. Алга байна. Ингээд санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгэе.

Ингээд санал хураалтыг явуулъя. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар улируулан сонгох нь зүйтэй гэсэн томъёоллоор саналыг хураах юм байна. Санал хураалтыг явуулъя. 88,2 хувиар буюу 17-15. Болормаа гишүүн дэмжсэнээр 16 гишүүн дэмжлээ.

Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Батсүмбэрэл гишүүн танилцуулъя. Ингээд Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууслаа. Та бүхэнд баярлалаа.

10.02 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ